



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн цахилгаан дамжуулах сүлжээ барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил, барилгын ажлын техник, технологийн байнгын хяналтыг хэрэгжүүлэхийг “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ч.Саранжавт даалгасугай.

2.Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ажлыг гүйцэтгэх ерөнхий гэрээг “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газартай хууль тогтоомжийн хүрээнд байгуулан захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноровт даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА